

“ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН БАРОМЕТРИЙН СУДАЛГАА ”

ТЕХНИКИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

- 1. Ерөнхий мэдээлэл** “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа”-ны мэдээлэл цуглуулах, мэдээллийн сан үүсгэх ажлыг захиалагчийн мэргэжил, арга зүйн удирдлага, хяналт дор гүйцэтгэх
- 2. Зөвлөхийг сонгох ажиллагаа** Зөвлөх үйлчилгээний зарлалыг 2020 оны 05 дугаар сарын 01-нд “Өнөөдөр сонин”-д болон www.tender.gov.mn хаягаар нийтлүүлсэн ба 2 байгууллага оролцох хүэсэлт ирүүлсэн бөгөөд үнэлгээний хорооны шийдвэрээр 2 байгууллагыг нэмж оролцуулан хураангуй жагсаалт үүсгэн тендерийн урилга хүргүүлсэн. Хураангуй жагсаалтад орсон, тендерийн урилга хүргүүлсэн байгууллагуудаас “Эс Ай Си Эй” ХХК, “Эм Эм Си Жи” ХХК-ууд тендер ирүүлсэн.
- 3. Техникийн саналын үнэлгээ** Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгаа институтийн захирлын 2020 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/03 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо, гишүүдийн 80 хувийн ирцтэйгээр техникийн саналд үнэлгээ хийж гүйцэтгэв. Үнэлгээнд “Зөвлөх үйлчилгээний тендерийн үнэлгээний заавар”, “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг тус тус мөрдлөг болгон ажиллалаа.

ЗҮТББ-д заасан үнэлгээний дэд үзүүлэлт болон холбогдох онооны талаарх үндэслэл:

- (а) Зөвлөхийн ажлын даалгаварт заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэж байсан тусгайлсан туршлага
- (б) Зөвлөхийн санал болгож буй ажлын хөтөлбөр болон аргачлал нь ажлын даалгаварын шаардлагад нийцсэн байдал
- (в) Зөвлөхийн үйлчилгээг гүйцэтгэх ахлах судлаач, судлаачдын чадвар болон туршлага

ТББ-ийн ТӨХ-ийн 1.1-д зааснаар Чанарын үнэлгээний аргаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 38.3 зүйлд зааснаар техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан зөвлөхийн санхүүгийн саналыг нээж, тухайн зөвлөхтэй санхүүгийн болон бусад нөхцөлийг харилцан тохиролцох хэлэлцээр хийх зарчмаар зохион байгуулж явууллаа..

Үнэлгээний хорооны үнэлгээгээр техникийн санал нь хамгийн өндөр оноо авсан “ММСГ” ХХК-тай санхүүгийн санал болон бусад нөхцлийг тохиролцсоны үндсэнд “Хөдөлмөрийн зах зэлийн эрэлтийн барометрийн судалгаа”-ны мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах эрх олголоо.